



СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

Хамрагдсан байгууллага: СҮХБААТАР АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ГАЗАР

Тайлангийн код: СХШУДАГ-2026/ДА/01

Сүхбаатар аймаг
2026 он

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1. Байгууллагын тухай.....	2
2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ	2
2.1. Аудитын зорилго	2
2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт	3
2.3. Аудитын арга, аргачлал.....	3
3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА.....	3
3.1. Засаглалын удирдлагын талаар	4
3.2. Эрсдэлийн удирдлагын талаар	4
3.3. Дотоод хяналтын талаар	4
4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР	5
4.1. Төсөвт байгууллагын төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, зарцуулалт;.....	6
4.2. Төрийн аудитаас 2024 онд өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт;	7
4.3. Шилэн дансны тухай хуулийн 2025 оны хэрэгжилт;.....	7
4.4. Салбарын сайдын 2025 оны төсвийн багцаас харьяа байгууллагуудад олгосон үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн зарцуулалт, үр дүнг үр дүнд суурилсан эсэхийг хянах; ...	8
5. АУДИТЫН ҮР ДҮН	9
6. НЭГДСЭН ДҮГНЭЛТ	10

1. ТАНИЛЦУУЛГА

Монгол улсын Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д заасан “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.3 “Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа хамаарна”, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.4 “Яам нь харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал, бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх арга хэмжээ авна.” Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.2, 7.3, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/101 дүгээр тушаалаар баталсан “Сүхбаатар аймаг дахь харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх” удирдамжийн дагуу Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2025 оны зарим үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Энх-Амгалан ахалж, Ахлах шинжээч Ц.Алтанхуяг, дотоод аудитор, Ахлах мэргэжилтэн Ч.Одгэрэл нар 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс 04 дүгээр сарын 02-ны өдөр хүртэл хийж гүйцэтгэлээ.

1.1. Байгууллагын тухай

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 168 дүгээр тогтоолоор “Боловсрол, соёл, урлагийн газар” гэснийг “Боловсролын газар, Соёлын хэлтэс” гэж өөрчлөн тус аймагт Соёлын хэлтсийг анх байгуулсан.

Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн “Аймгийн засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377 дугаар тогтоол, Соёлын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн “Аймаг нийслэлийн Соёл, урлагийн газрын зохион байгуулалтын бүтэц, дүрэм батлах тухай” 04 дүгээр тушаалаар Сүхбаатар аймгийн Соёл, урлагийн газрыг 11 орон тоотойгоор байгуулсан.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 12 сарын 16-ны өдрийн А/435 дугаар тушаалаар байгууллагын стратеги төлөвлөгөө, зохион байгуулалтын бүтцийг 15 орон тоотой байхаар шинэчлэн баталсан.

Байгууллагын регистрийн дугаар 3683737, Төрийн сан банканд үндсэн үйл ажиллагааны 100120034003, нэмэлт санхүүжилтийн 100120034401 дугаар харилцах дансаар бэлэн бус төлбөр, тооцоог хийсэн.

Аудитад хамрагдах хугацаанд нэгдүгээр гарын үсгийг 2023 оны 12 сарын 25-ны өдрөөс эхлэн дарга Б.Золхүү, хоёрдугаар гарын үсгийг 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс нягтлан бодогч Б.Болормаа нар тус тус зурж хөрөнгө, мөнгийг захиран зарцуулжээ.

Тус байгууллага нь 2025 оны жилийн эцсийн санхүү, татвар, нийгмийн даатгалын тайлангуудыг хуулийн хугацаанд нь холбогдох байгууллагуудад гарган өгч баталгаажуулсан байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1. Аудитын зорилго

Тус байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлж, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт

шалгалт хийн, дүгнэж, илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах, зөвлөмж өгөх байдлаар байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилго баримтлан ажилласан.

2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Хамарсан хүрээ: Тус байгууллагын 2025 оны зарим үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ. Үүнд.

- Төсөвт байгууллагын төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, зарцуулалт;
- Төрийн аудитаас 2024 онд өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт;
- Шилэн дансны тухай хуулийн 2025 оны хэрэгжилт;
- Салбарын сайдын 2025 оны төсвийн багцаас харьяа байгууллагуудад олгосон үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн зарцуулалт, үр дүнг үр дүнд суурилсан эсэхийг хянах;

Хязгаарлалт: Дээрх асуудлаас бусад үйл ажиллагааг хязгаарласан болно.

2.3. Аудитын арга, аргачлал

Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, Соёлын сайдын 2022 оны А/118 дугаар тушаалаар баталсан “Дотоод аудитыг гүйцэтгэх аргачлал”-ыг мөрдөж дотоод аудитыг гүйцэтгэсэн болно.

Аудитад дараах хууль эрх зүйн актуудыг шалгуур болгосон. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай;
- ✓ Төрийн аудитын тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Шилэн дансны тухай хууль;
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль;
- ✓ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
- ✓ Соёлын тухай хууль;
- ✓ Соёлын өвийг хамгаалах тухай хууль;
- ✓ Музейн тухай хууль;
- ✓ Нийгмийн даатгалын тухай хууль;
- ✓ Бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт

3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

Сүхбаатар аймгийн соёл, урлагийн 15 байгууллагын удирдлагуудтай “Хамтран ажиллах гэрээ”-гээ байгуулахдаа жил бүр өөр сумандаа зохион байгуулж, үйл ажиллагааг нь сурталчлан таниулах, туршлага судлах ажлыг хийж хэрэгжүүлээд хэвшсэн байна.

“Аялал жуулчлалын анхдугаар зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, Сүхбаатар аймгийн хөтөч номыг гаргасан байна.

Тус байгууллага нь 2024 онд “Хүүхдэд ээлтэй эцэг эхийн зөвлөл” тэргүүн байрт шалгарч улмаар салбарын 15 байгууллагад нөлөөллийн ажил эхлүүлж 2025 онд 10 байгууллага нь хүүхдийн өрөө байгуулж ажилтан албан хаагчдын хүүхдүүд тоглох, хичээл хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

3.1. Засаглалын удирдлагын талаар

Газар нь соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын салбарын хууль тогтоомж, бодлого, стратегийг хэрэгжүүлэх, орон нутгийн засаг захиргааны бодлогыг хэрэгжүүлэх үүрэг, хариуцлагыг хүлээж, хариуцсан чиг үүргийн дагуу иргэд, олон нийтэд шуурхай, мэргэжлийн үйлчилгээг үзүүлнэ гэж үйл ажиллагааны стратегид заасны дагуу тус байгууллагын 2025 оны үйл ажиллагааг үнэлж Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам 93.5 хувь, Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар 93.5 хувь тус тус дүгнэсэн байна.

Хууль эрх зүйн хүрээнд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой А тушаал 51, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой Б тушаал 27 нийт 78 тушаал шийдвэрийг төлөвлөн гаргасан байна. Мөн зохион байгуулалт, мэдээлэл лавлагааны баримт бичгийн хүрээнд ер цахим системээр явуулсан бичиг 337, ирсэн бичиг 182 байна. Үүнээс цаасаар явуулсан бичиг 132, ирсэн бичиг 110 байна.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 23 дугаар тогтоолын дагуу зохион байгуулагдсан “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын урьдчилсан үзлэг”-ийн нэгдсэн дүнгээр 86,7 хувьтай дүгнэгдсэн байна.

Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/05 дугаар тушаалаар шинэчлэн баталсан байна.

Бүтэц, орон тооны талаар:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 12 сарын 16-ны өдрийн “Аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” А/435 дугаар тушаалаар байгууллагын стратеги төлөвлөгөө, зохион байгуулалтын бүтцийг 15 орон тоотой байхаар шинэчлэн баталсан. Үүний дагуу аудитад хамрагдах хугацаанд тус байгууллага нь Захиргаа удирдлагын хэлтэс, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс нийт 13 албан хаагчийн бүтэц орон тоотой үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тус онд төрийн жинхэнэ албаны тусгай шалгалтаар 1, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Сүхбаатар аймгийн Төрийн албаны салбар зөвлөлтэй зөвшилцөн 2 албан хаагчдыг шилжүүлэн томилж байгууллагын сул орон тоог нөхөх арга хэмжээ авч ажилласан байна.

Мөн 6 сумын Соёлын төвийн дарга нарын албан тушаалын сул орон тоог нийтэд зарлаж, сонгон шалгаруулалт явуулах талаар сумдын засаг дарга нарт чиглэл өгч 4 сумын Соёлын төвийн дарга нар шалгалт өгч тэнцэн жинхлэгдсэн байна.

3.2. Эрсдэлийн удирдлагын талаар

Тус байгууллага нь эрсдэлээ тодорхойлж, үнэлдэггүй. Байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл явцын талаар ажлын баримт АБ1003-аар 8 асуулга авч, дотоод аудитын аргачлалд заасан 8 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Эхлэлийн буюу 1-р түвшин”-нд байна.

3.3. Дотоод хяналтын талаар

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын дагуу байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх эрх бүхий дотоод хяналтын ажлын хэсгийг даргын 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/22 дугаар тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байхаар байгуулсан байна.

Аудитад хамрагдах хугацаанд нийт 21 ажил хийхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар гаргаагүй тул дүгнэх боломжгүй байна. Харин жилийн эцсийн байдлаар зохион байгуулсан ажлын талаар бичмэл тайлан гаргасан байна.

Дотоод хяналтаар төлөвлөсөн ажлын 12 нь байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой, 4 ажил нь гадагшаа чиглэсэн хяналтыг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Тухайлбал:

- ✓ Музейн үзмэр, сан хөмрөг, хадгалалт хамгаалалт
- ✓ Номын сангийн үйл ажиллагаа, баяжилт, сан хөмрөг
- ✓ Дуу хөгжмийн багшийн сургалтын төлөвлөгөө, тайлан, дугуйлангийн үйл ажиллагаа
- ✓ Бүжгийн багшийн сургалтын төлөвлөгөө, тайлан, дугуйлангийн үйл ажиллагаа

Дотоод хяналтыг хэрэгжүүлэхдээ төлөвлөсөн 21 ажлыг тусган “Соёл, урлагийн салбар байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөвлөн туслах тухай” нэг удирдамжаар дотогшоо болон гадагшаа чиглэсэн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн байдал: Байгууллагын санхүү байдлын тайлангаар нийт хөрөнгө 2025 онд 150,349.6 мянган төгрөг байна.

Санхүүгийн байдлын тайлан Хүснэгт 1 (мянган төгрөг)

Үзүүлэлт	2025 оны 12 сарын 31		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /3-2/
1	2	3	4
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	59.1	0	(59.1)
Бараа материал	16,432.2	17,904.7	1,472.5
Үндсэн хөрөнгө	158,469.2	132,444.9	(26,024.3)
Нийт хөрөнгө	174,960.6	150,349.6	(24,611.0)
Өглөг	18.1	0	(18.1)
ЗГ-ын оруулсан капитал	174,942.5	127,295.5	(47,647.0)
Өр төлбөр, цэвэр хөрөнгийн өмчийн дүн	174,960.6	150,349.6	(24,611.0)

Үйл ажиллагааны санхүүжилтийн талаар:

Тус Байгууллагын 2025 оны төсвийн төслийг 647,480.0 мянган төгрөгөөр боловсруулан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд хүргүүлсэн. Байгууллагын төсвийг нийт 582,122.9 мянган төгрөгөөр баталсан. Үүнээс улсын төсвөөс 557,246.5 мянган төгрөгийн санхүүжилт ирсэн. Гүйцэтгэлээр 523,053.6 мянган төгрөгийг зарцуулж, төвлөрүүлсэн дүн 34,192.8 мянган төгрөг байна.

Орон нутгийн төсвөөс нийт 57,484.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 57,484.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсөвт хөрөнгийн зарцуулалтын талаар:

Төсвийн гүйцэтгэл Хүснэгт 2(мянган төгрөг)

№	Эх үүсвэр	2025 оны 12 сарын 31		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	528,811.4	523,053.5	92.6
2	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	528,811.4	491,565.5	92.6
3	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	438,363.5	407,597.7	92.9

4	Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл	54,824.6	51,411.4	93.7
5	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,753.2	12,753.3	100
6	Хангамж, бараа материалын зардал	13,568.8	10,636.3	78.3
7	Томилолт зочны зардал	1,840.0	1,840.0	
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	3,131.4	3,000.0	95.7
9	Бараа үйлчилгээний бусад зардал	4,326.8	4,326.7	100
10	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	22,527.6	14,524.2	64.4
11	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	30,783.9	16,963.8	
12	Төвлөрүүлсэн дүн		34,192.8	55.1
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	582,122.9	557,246.4	95.7
14	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	582,122.9	557,246.4	95.7

4.1. Төсөвт байгууллагын төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, зарцуулалт

Бараа материалын талаар:

Бараа материал 2025 оны эхэнд 16,432.2 мянган төгрөг, жилийн эцсийн байдлаар 17,904.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материал

Хүснэгт 3 (мянган төгрөг)

Д/д	Төрөл	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Бичиг хэргийн материал	297.9	4,831.8	4,859.7	270.0
2	Аж ахуйн материал	1,006.9	15,378.2	15,363.2	1,021.9
3	Шатахуун	170.0	5,150.0	5,320.0	0
3	Эм боох материал	-	40.1	40.1	-
5	Барилгын засварын материал	1,122.0	39.1	39.1	1,122.0
6	Бусад хангамжийн материал	13,835.4	2,284.6	629.3	15,490.8
Дүн		16,432.2	27,723.9	26,251.5	17,904.7

Нийт бараа материалын 86.5 хувийг бусад хангамжийн бараа материал, үлдсэн 13.5 хувийг бусад бараа материал эзэлж байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 27,723.9 мянган төгрөгийн бараа материалын худалдан авч, 26,251.5 мянган төгрөгийн бараа материалыг шаардах хуудсаар, зарлагын баримт үйлдэж зарцуулан тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгийн талаар:

Үндсэн хөрөнгө 2025 оны эхэнд 187,197.9 мянган төгрөг, жилийн эцсийн байдлаар 191,637.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө

Хүснэгт 4 (мянган төгрөг)

Д/д	Төрөл	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Авто тээвэр	67,500.0	-	-	67,500.0	18,750.0	48,750.0
2	Машин тоног төхөөрөмж	60,429.8	3,120.0	-	63,549.9	19,426.6	44,123.3
3	Тавилга эд хогшил	36,308.0	-	-	36,308.0	11,333.8	24,974.2

4	Бусад үндсэн хөрөнгө	21,460.0	1,320.0	-	22,780.0	8,582.5	14,197.4
5	Программ хангамж	1,500.0	-	-	1,500.0	1,100.0	400.0
Дүн		187,197.9	4,440.0	-	191,637.9	59,192.9	132,444.9

Нийт хөрөнгийн 36.8 хувийг тээврийн хэрэгсэл, 33.3 хувийг машин тоног төхөөрөмж, 18.8 хувийг тавилга эд хогшил, үлдсэн 11.1 хувийг бусад хөрөнгө эзэлж байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 1,320.0 мянган төгрөг, хандиваар 3,120.0 мянган төгрөгөөр машин тоног төхөөрөмж авсан байна. Нийт 4,440.0 мянган төгрөгийн хөрөнгийн данс бүртгэлд тусгасан. Акталж, данс бүртгэлээс хассан хөрөнгө байхгүй.

4.2. Төрийн аудитаас 2024 онд өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд Сүхбаатар аймгийн Төрийн аудитын газар санхүүгийн аудит хийж гүйцэтгэсэн. Санхүүгийн тайлангийн аудитаар 3 нэр төрлийн алдаа зөрчил илэрч албан шаардлага, 2 зөвлөмж, нийцлийн аудитаар 1 алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлж ажилласан байна. Хэрэгжилт 95 хувьтай байна.

Төрийн аудитаас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмж

Хүснэгт 5 (мянган төгрөг)

Шийдвэрийн төрөл	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн товч утга	Мөнгөн дүн	Хэрэгжүүлсэн байдал
Албан шаардлага	Санхүүгийн ажилтанд 1,114.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгосон нь үр дүнгийн урамшуулалтай давхардуулсан.	1,114.0	2025 онд санхүүгийн ажилтанд балансын урамшуулал олгоогүй байна. Биелэлт 100 хувь.
Зөвлөмж	Албан ажлын автомашинд MNS 4598 стандартад заасан мэдээлэл, хяналтын төхөөрөмж буюу GPS суурилуулах.	-	Автомашинд мэдээлэл хяналтын төхөөрөмж GPS суурилуулсан байна. Биелэлт 100 хувь.
Зөвлөмж	Албан томилолт олгохдоо Засгийн газрын 2019 оны 6 тогтоолын төсөв захирагч шийдвэр гаргаж, томилолтын зардлын 50 хувийг урьдчилан олгож байх.	-	Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчийн байр, хоол, унааны зардлын төсвийг байгууллагын эрх бүхий албан тушаалтан батална заалтыг хэрэгжүүлж ажилласан байна. Биелэлт 100 хувь
Зөвлөмж	Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг үнэн зөв иж бүрэн мэдээлж байх.	-	Тайлант онд 171 мэдээлэл оруулахаас 168 мэдээлэл хугацаандаа, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Биелэлт 80 хувьтай.
Нийт		1,114.0	

4.3. Шилэн дансны тухай хуулийн 2025 оны хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим системд 2025 онд 24 нэр төрлийн 171 мэдээлэл оруулахаас 3 мэдээ хугацаа хоцроосон.

Тус байгууллага нь Хандив, тусламжийн орлого, зарцуулалтын тайлан талбарт нийт 3,120.0 мянган төгрөгийн мэдээлэл оруулаагүй байна

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1 “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

4.4. Салбарын сайдын 2025 оны төсвийн багцаас харьяа байгууллагуудад олгосон үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн зарцуулалт, үр дүн

Соёлын сайдын 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн “Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлалыг шинэчлэн батлах тухай” А/390 дүгээр тушаалын хавсралтаар “Соёлын байгууллагын үр дүнд суурилсан санхүүжилтийг баталсан.

Дээрх аргачлалын дагуу Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдан 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн “Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн төсвийн хуваарилалт батлах тухай” А/212 дугаар тушаалаар төсвийн хуваарилалтыг баталж, тайлант онд Сүхбаатар аймгийн салбарын 15 байгууллага нийт 176,408.8 мянган төгрөгийн үр дүнд суурилсан санхүүжилтийг авсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6 (мянган төгрөг)

№	Байгууллагын нэр	2023 он	2024 он	2025 он
1	Уулбаян соёлын төв	6,971.0	5,697.0	10,123.0
2	Түвшинширээ соёлын төв	7,576.0	7,545.0	8,646.0
3	Түмэнцогт соёлын төв	7,432.0	7,906.0	8,290.0
4	Наран соёлын төв	7,031.0	7,910.0	8,076.0
5	Дарьганга соёлын төв	5,370.0	6,746.0	7,730.0
6	Баяндэлгэр соёлын төв	9,534.0	6,599.0	7,657.0
7	Мөнххаан соёлын төв	6,105.0	6,214.0	8,071.0
8	Сүхбаатар соёлын төв	8,899.0	7,358.0	7,149.0
9	Асгат соёлын төв	11,721.0	6,102.0	7,034.0
10	Халзан соёлын төв	3,876.0	6,538.0	6,564.0
11	Онгон соёлын төв	7,287.0	7,930.0	6,276.0
12	Эрдэнэцагаан соёлын төв	7,707.0	7,703.0	4,495.0
13	Жаахан шарга театр	42,345.0	66,183.0	68,347.0
14	Музей	20,280.0	17,505.0	14,771.0
15	Нийтийн номын сан	8,825.0	25,597.0	6,416.0
	Нийт дүн	160,958.2	193,533.0	176,409.6

Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилт олгогдсоноор санхүүжүүлэх боломжгүй үндсэн үйл ажиллагаатай холбоотой хөтөлбөр арга хэмжээ, дотоод үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамруулах ажлуудыг зохион байгуулсан байна. Тухайлбал:

- ✓ Салбарын хэмжээнд 2024-2025 онд үр дүнд суурилсан санхүүжилт болон өөрийн орлогоос гадаадад-3, Улаанбаатар хотод 9, Хэнтий аймагт-2 байгууллага эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан бөгөөд 1 ажилтны хавдрын өвчин илэрч эмчилгээ хийлгэсэн.
- ✓ Үр дүнд суурилсан санхүүжилт болон байгууллагын өөрийн орлогоор 72.8 сая төгрөгийн тавилга тоног төхөөрөмж, ном, тээврийн хэрэгсэл худалдан авсан.

5. АУДИТЫН ҮР ДҮН

Илэрсэн асуудал 1	Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэргүй нийт 4,440.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан.
Асуудлын ангилал	Нөлөө багатай
Бодит байдал: Шинээр худалдан авсан 1,020.0 мянган төгрөг, хандиваар 3,120.0 мянган төгрөг нийт 4,440.0 мянган төгрөгийн хөрөнгийг өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр, данс бүртгэл тусгах тушаал шийдвэргүйгээр хөрөнгийн данс бүртгэлд тусгасан байна.	
Шалгуур үзүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 65 дугаар тогтоолын хавсралт “Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 5.2 Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь өмч хамгаалах байнгын зөвлөлийн зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, акталж данснаас хасах санал хүргүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд зөвлөл нь дор дурдсан шаардлагыг хангаж, төрийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагад хүсэлтийг хүргүүлэх ажлыг зохион байгуулна” заалтуудад нийцээгүй байна.	
Асуудлын үндсэн шалтгаан: Дүрэм журмыг мөрдөөгүй.	
Үр нөлөө:	
Зөвлөмж: “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын дагуу байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын шийдвэрийг гаргуулан, данс бүртгэлд тусгах тушаал шийдвэр гарган хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж байх.	

Илэрсэн асуудал 2	Дотоод хяналтыг гадагшаа чиглэсэн хяналт хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгасан. Дотоод хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт гаргаагүй. Төлөвлөгөөнд тусгасан хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй.
Асуудлын ангилал	Нөлөө багатай
Бодит байдал: Дотоод хяналтаар төлөвлөсөн ажлын 12 нь байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой, 4 ажил нь гадагшаа чиглэсэн хяналтыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.	
Шалгуур үзүүлэлт: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “ААНБ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.7.1 "зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах"	
Асуудлын үндсэн шалтгаан: Хууль тогтоомж, дүрэм журмыг бүрэн хэрэгжүүлээгүй.	
Үр нөлөө: Байгууллагын үндсэн үйл ажиллагаа, төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэл үүсэх.	
Зөвлөмж: Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг зохион байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргах. Илэрсэн алдаа дутагдлыг арилгуулан үр дүнг хамт олонд мэдээлж байх.	

Илэрсэн асуудал 3	Шилэн дансны цахим системд 2025 онд 24 нэр төрлийн 171 мэдээлэл оруулахаас 3 мэдээ хугацаа хоцроосон. Хандив, тусламжийн орлого, зарцуулалтын тайлан талбарт нийт 3,120.0 мянган төгрөгийн мэдээлэл оруулаагүй байна.
Асуудлын ангилал	Нөлөө багатай

Бодит байдал: 3 мэдээлэл хугацаа хоцроосон.
Шалгуур үзүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл "Шилэн дансны зарчим" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"; 6.3. Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна: 6.3.5. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт;
Асуудлын үндсэн шалтгаан: Шилэн дансны шинэчилсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулах аргачлал, зааврыг бүрэн хэрэгжүүлээгүй үйлдэл, эс үйлдэл.
Үр нөлөө: Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай, Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх.
Зөвлөмж: Давтан гаргахгүй байх. Шилэн дансны тухай хуулийн мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлж байх.

6.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Тус байгууллага нь батлагдсан төсвийн хүрээнд төсөв, санхүүг захиран зарцуулсан байна. Хяналт шалгалтын явцад өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаа хангалтгүй, тус зөвлөлийн хурлын шийдвэргүй хөрөнгө данс бүртгэлд бүртгэсэн асуудал илэрлээ.

Цаашид холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдөн ажиллах, өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаа болон дотоод хяналтыг сайжруулах, хяналт шалгалтаар илэрсэн асуудлыг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Иймд "Аудит, хяналт шалгалтаар илэрсэн асуудлуудын 20 хувь нь "нөлөө ихтэй" гэж үзсэн үед өгдөг "Хангалттай" үнэлгээг өгөв.

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ